



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/647

Ховд

Хөрөнгө гаргаж дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "г", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусийн халдварын улмаас эх нь нас барж өнчирч үлдсэн Ц.Баян-Эрдэнэ нярайд хоол тэжээл, шаардлагатай бусад хэрэгцээтэй зүйлсийг олгох, эрүүл өсч бойжиход нь зориулж 5 000 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Хүү Ц.Баян-Эрдэнэд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 5 000 000 төгрөг /таван сая/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний 4.2 дахь "Эх хүүхдэд ээлтэй тусламж үйлчилгээ" хөтөлбөр, төслийн зардлаас тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ